

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Түмэн Цацал” ХХК нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших МҮ-016920 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын газраас 40 жилийн хугацаатай авсан.

2019 оноос “Ширээ Уул 2” гөлтгөний ордод ашиглалтын үйл ажиллагааг явуулаж эхэлсэн энэ хугацаанд Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох дүрэм журмыг мөрдөн ажилладаг аж ахуй нэгж юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд БОНБНҮ / 2019 он / тайлан болон БОАЖЯ төслийн ерөнхий үнэлгээний дүгнэлт /2018. 09. 20/ тусгаж Байгаль орчныг хамгаалахтай холбоотой болзошгүй болон сөрөг нөлөөлөлийг бууруулах, арилгах арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.

Түмэн Цацал ХХК нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд болохын хувьд “Байгаль орчныг хамгаалах тухай” Ашигт малтмалын тухай, Монгол улсын хуулийн дагуу байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх, үйл ажиллагааны хэрэгжилтийг тайлагнахад тус тайлангийн зорилго оршино.

### 1.1. ОРДЫН БАЙРШИЛ

“Ширээ уул-II” гөлтгөний орд нь Улаанбаатар хотоос баруун урд зүгт 460 км, Дэлгэрхангай сумын төвөөс баруун урд зүгт 50 км, Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумаас зүүн хойш 45 км оршино. Улаанбаатар Өмнөговийг холбосон хатуу хучилттай зам тусгай зөвшөөрлийн талбайн хилийн зүүн талаар 100-110 км (хамгийн ойр зай) зайтай өнгөрдөг.

- Ордын нэр: “Ширээ уул-II” гөлтгөний орд
- Засаг захиргаа: Дундговь аймаг, Дэлгэрхангай сум
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Гөлтгөнө
- Тусгай зөвшөөрлийн талбайн планшет: L-48-101
- Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ: 31. 98 га.


**Тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицлууд**

**Хүснэгт № 1.**

Цэгийн дугаар	Талбайн солбицлууд	Газарзүйн солбицлын систем			Метрийн солбицлын систем	
		Град	Мин	Сек	/UTM/	
1	Уртраг	104	20	47. 11	Y	448,472. 167
	Өргөрөг	44	58	56. 97	X	4,981,213. 204
2	Уртраг	104	20	20. 11	Y	447,880. 872
	Өргөрөг	44	58	56. 97	X	4,981,217. 999
3	Уртраг	104	20	20. 11	Y	447,885. 284
	Өргөрөг	44	59	14. 5	X	4,981,758. 931
4	Уртраг	104	20	47. 11	Y	448,476. 310
	Өргөрөг	44	59	14. 5	X	4,981,754. 138


Төсөл хэрэгжих талбайн байршлын тойм

зураг 1



Төслийн талбай /Google earth/

Зураг 2



**Төсөл хэрэгжүүлэгч компаний мэдээлэл**

**Хүснэгт 2**

ААНХэлбэр	ААНэр	Улсын бүртгэл	РД	Хаяг байршил
ХХК	Түмэн Цацал	9011050062	5108713	ЧД 4-р хороо, Бага тойруу 19-32 тоот

**ТӨСЛИЙН ТҮҮХ**

Төсөл эхэлсэн түүх Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Түмэн Цацал ХХК нь “Ширээ уул 2” гөлтгөний ордод төлөвлөгөөний дагуу 2019. 07. 18-ний өдрөөс С2-1 блокын хэсгээс хөрс хуулаж олборлолтын үйл ажиллагааг эхлүүлж 2019. 08. 30 өдрөөс уранши хийж хатааж ангилан цементийн үйлдвэрт нийлүүлж эхэлсэн.

**2. УУРХАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

“Ширээ Уул 2” гөлтгөний ордын ТЭЗҮ-г УУХҮЯ болон АМГТГ-ын ЭБМЗ -өөр 2018. 07. 18 өдөр хэлэлцэж дугаар Т/18-08-07 тоот дүгнэлтийг гаргасан. Энэ дүгнэлтийг үндэслэн АМГТГ-ын даргын 2018. 08. 01 өдөр дугаар Т/80 тоот тушаалаар “Ширээ Уул 2” гөлтгөний ордын нөөцийг II-IVхайгуулын шугамын хоорондын нөөц МҮ-016920 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл талбайд хамрагдахнөөц С<sub>2</sub> зэргээр гөлтгөнө 258,82 мян/тн конкрецид 1263,68 мян/тн шавар дахь гөлтгөнө 74,25 мян/тн буюу нийт 1596,75мян/тн нөөц бүртгэсэн.

БОНБНҮ 2018онд эрх бүхий байгууллагаар хийлгэсэн жил бүр БХМТ-г БОНБНҮ-тэй уялдуулан боловсруулаж орон нутгийн захиргаа , БОАЖЯ-аар хянуулан ажиллаж байна.

**БОНБҮ тайлан мэдээлэл**

**Хүснэгт 3**

Уурхай	БОНБЕҮ	БОНБНҮ
Ширээ Уул 2	2018. 09. 20 N13/6611	2018

Байгаль хамгаалах төлөвлөгөө нь Ширээ Уул 2 гөлтгөнө ордын олборлохтой холбоотой үйл ажиллагаа, сөрөг нөлөөлөлийг хууль эрх зүйн шаардлагын дагуу багасгах арилгах арга хэмжээ шаардлагатай судалгаа шинжилгээ нөхөн сэргээлтийн бэлтгэлийг төлөвлөж хэрэгжилтийг тайлагнах бичиг баримт юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд уурхайн БОНБНҮ -ний тайланд туссан болзошгүй болон сөрөг нөлөөлөлийг бууруулах арилгах арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус компани нь ашиглалтын үйл ажиллагаа явагдаж байгаатай холбогдуулан байгаль орчинд зохистой менежментийг төлөвлөн жил бүр сайжруулах зорилт тавин ажиллаж байна.

**2.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГЫН ЗОРИЛГО**  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь “Ширээ Уул 2” гөлтгөний ил уурхайн үйл ажиллагааны явцад байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилготой.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллав.

Үүнд :

- Уурхайн үйл ажиллагаанд хамрагдах байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нөхцөлийг хангах
- БОНБНҮ-ний заалтуудыг хэрэгжүүлэх
- Төслийн талбайд байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх
- Уурхайн үйл ажиллагаанд оролцогч байгууллага болон тээвэрлэгчид үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ тодорхойлох
- Тусгай зөвшөөрлийн талбай хэмжээнд үйл ажиллагаа эрхлэн газар ашиглалт, үйл ажиллагаа, байгаль орчны хяналт тавих хамтран ажиллах.
- Талуудын оролцоог хамруулах тайлангах тогтолцоог сайжруулах

**2.2 Дэд бүтэц:** Дундговь аймаг нь эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон. Цахилгаан хангамж бүрэн шийдэгдсэн. Холбоо харилцаа мөн сайн хөгжсөн. Дэлгэрхангай сум нь дэд бүтцийн хувьд сулавтар төвийн нэгдсэн цахилгаан сүлжээнд холбогдсон.

Тус ордын хувьд цахилгааны асуудлаа генератороор шийдвэрлэдэг. Цахилгаан аолбооны хувьд “Жи Мобилийн сүлжээ ашигладаг.

### **2.3 ФИЗИК ГАЗАР ЗҮЙ, УС ЗҮЙ, ЦАГ УУР**

**Газар зүй:** Ширээ уулын 2 гөлтгөний орд нь Монгол орны физик газар зүйн мужлалаар төв Монголын говь хээрийн бүсэд орших ба тэгш талархаг рельефтэй, үнэмлэхүй өндөр далайн түвшнээс дээш 1160-1200 м хүртэл өргөгдсөн, тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үнэмлэхүй өндөр далайн түвшнээс дээш 1165-1175 м хооронд хэлбэлзэнэ. Талбайн орчмын гадаргуугийн ерөнхий налуу нь зүүн хойноос баруун өмнө зүгт буюу Онгийн голын хөндийн чигт намсах байдалтай, гадаргын хэлбэр дүрс нь жижиг толгодорхог, уулс хооронд өргөн уудам тэгш талын рельефтэй.

Ерөнхийдөө үндсэн гарш муу, толгодын хоорондох хөндий маягийн тэгш гадаргуу нь элсээр дүүрч, үндсэн гарш ажиглагдахгүй байдаг. Гадаргуугийн ийм орчимд элэгдэл идэгдлийн үйл ажиллагаа сул явагдаж, усан сүлжээ муу хөгжсөн, бэсрэг уулсаас эх авсан хуурай сайрууд нь хэрчигдэл багатай, хэдэн зуун метрээс хэдэн километр үргэлжилж хоолой хөндийн тэгш гадаргад шилжинэ.

**2.4 Ус зүй:** Төслийн талбайгаас 20 гаруй км зайд Онги гол урсдаг бөгөөд урсгал ус, горхи, булаг энэ районд байхгүй. Ширээгийн хөндийн гөлтгөний орд нь ерөнхий зүүн хойд чигийн суналтай тогтол зүйн гаралтай зурвас хөндийд байрлана. Ус агуулагч хурдсын найрлагад мөхлөгийн бүрэлдэхүүний хувьд янз бүр элсжин, хайргажин ба зануу төст шавар, алеврит, мишлүүд налууудуу үелэл үүсгэнэ. Ордын гидрогеологийн нөхцөл байдал нь хуурай,

Төслийн талбайд N 44° 59' 20" E 104° 20' 48 усны цэг илэрч 60м гүнтэй гүний худаг гаргасан Гүний ус нь химийн найрлагаараа гидрокарбонат натрийн ангилалд багтах ба цэнгэгдүү, зөөлөвтөр ус боловч бохирдолт нь ундны усны стандартаас их байна. Ан цавын ус нь дунд рифейн настай хувирмал чулуулаг, дунд девон, доод пермийн настай гүний чулуулаг тархсан талбайд ан цав, тектоник хагарлыг дамжин үүссэн байдаг. Талбайгаас зүүн хойш 13 км-т хуучин өрөмдсөн цооногоос ус даралтаар байнга урсан гарч байдаг ба энэ нь ан цавын ус бөгөөд олон жилийн турш хүн, малын ундны хэрэгцээг хангаж байна.

**2.5 Цаг уур:** Төслийн бүс нутагт жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа урт (жилийн 360 хоногт агаарын дундаж температур энэ жилийн хувьд 410С-390С -ээс бага), агаарын температурын жилийн болонхоногийн хэлбэлзэл ихтэй, хур тунадас бага, үүлшил, агаарын чийгшил багатай эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг юм.

Төслийн бүс нутагт жилдээ 3152 орчим цаг нар гийгүүлэх бөгөөд Даланзадгад, Мандалговь хотоор баримжаалбал газрын гадарга дээр 5400 Мдж/м<sup>2</sup> хэмжээний нарны эрчим хүч ирдэг байна. Өөрөөр хэлбэл энэ бүс нутаг нь нарны эрчим хүчээр нэн баялаг юм. Агаарын температур хоногт дунджаар 12. 7<sup>0</sup>С байх бөгөөд хавар, намрын улиралд 13-17<sup>0</sup>С болж ихэсдэг.

**Агаарын температурын үзүүлэлт**

**Хүснэгт 4**

Сарууд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Дундаж	-16. 2	-10. 2	-3. 2	5	12. 4	19. 7	22. 4	19. 2	13. 2	4. 1	-5. 5	-13. 6
Хамгийн их	-1	4. 3	14. 5	21	29. 5	31. 7	39	41. 5	27	20. 6	9. 3	-1. 1
Хамгийн бага	-29. 3	-24. 9	-19. 2	-11. 8	-5. 2	4	7. 6	4. 9	-2. 6	-13. 2	-19. 7	-27. 1

Хөрсний гадаргын температур цасан бүрхүүл тогтсон өвлийн саруудад агаарын температураас 0. 3-1. 5<sup>0</sup>С -ээр хүйтэн, жилийн дулаан улирлын саруудад агаарынхаас 4. 0-10<sup>0</sup>С-ээр дулаан байдаг. 4-9 дүгээр сарын хооронд унах бөгөөд жилийн хүйтэн улиралд хур тунадас тун бага унана. Мөн тус бүс нутаг нь Монголдоо салхи ихтэй нутагт хамаарах бөгөөд жилийн дундаж салхины хурд 3. 6 м/с орчим, салхи шуурга харьцангуй ихтэй юм. Энэ жил хавар зуны эхэн саруудад гантай байлаа. Зуны дунд сараас чийг өгсөн.

## 2. 6 ХӨРС УРГАМАЛ, АМЬТНЫ АЙМАГ

**Хөрс ургамал:** Энэ газар нь хөрс-газарзүйн мужлалаар цөлөрхөг хээрийн хөрстэй Дэлгэрхангай-Сайншандын тойрогт хамрагддаг. Хур тунадас ховор, эрс гандуу уур амьсгалтай, өвс ургамал тарчиг сийрэг энэ талбай нь цөлөрхөг хээрийн бор хөрстэй.

Хээрийн бүс цөлийн бүсийн уулзвар болохоор хээр цөлийн мөн завсрын ургамалжилттай. Ихэвчлэн цөлөрхөг хээр, цөлийн ургамал зонхилдог. Зонхилогч ургамлын хувьд үетнээс дэрвээн хазаар өвс, говийн хялгана, алаг өвснөөс толгодын бударгана, таана хөмүүл ургана.

**Амьтны аймаг:** Энэ бүс нутагт говь цөлийн амьтад болох хулан, аргаль, янгир, хар сүүлт зэрэг туурайтан, махчин амьтдаас чоно, үнэг, өмхий үен, мануул, жигүүртнээс эвэрт болжмор, жиргэмэл, хөх цэгцгий, хээрийн шийхнүүхэй, адууч чогчиго, оронгийн бор шувуу, хээрийн бор шувуу, тагтаа, хэвлээр явагчдаас олон зүйл гүрвэл, могой, мэрэгчдээс туулай, алаг даага, шавьж идэштнээс дэлдэн зараа, шавьжаас хэдэн төрлийн аалз, арваалж байх ба эдгээр амьтдаас нэн ховордсон, устаж алга болохын даваан дээр байгаа төрөл, зүйлүүдийг агнах, устгахыг хориглож дархан цаазтай болгожээ

### 3. СӨРӨГ НӨЛӨӨЛӨЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

#### 3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Замын хөдөлгөөн, хөрс хуулалт тээвэрээс үүдэлтэй агаарын тоосжилтыг бууруулах

- Уурхайн технологийн замд тоосжилтыг бууруулах ажил
- Авто тээврийн үзлэг оншилгоо
- Түйрэн ихтэй эргэлтийг хусаж замын арчилгаа усалгааг нэмэгдүүлэх
- Уурхайн дотор 20 км/ цаг хурдтай явах тэмдэг тэмдэглэгээ хэрэгжүүлэх.
- Уурхай кемп 2-ын хооронд зам арчилгаа
- Уурхайн даргын замын усалгааны хувиарын дагуу 7 хоногт 1 удаа усалгаа хийж замын түйрэн ихтэй эргэлтийн замыг ковшоор түрж уурхай болон кемпийн хооронд тогтсон маршрутын замаар явуулах асуудалд хяналт тавьж ажилласан.

Тэмдэг тэмдэглэгээ Зураг 3





Зам арчилгаа Зураг 4



Авто үзлэг оншилгоо

Зураг 5



### 3. 2 БҮТЭЭГДЭХҮҮН ТЭЭВЭРЛЭЛТИЙН МАРШРУТ

Бүтээгдэхүүн тээвэрлэх замын маршрутыг мөрдөн ажиллаж байна. Тус замыг шинэчлэх маршрутыг Дэлгэрхангай сумын иргэдийн хурлаар өөрчилөх саналыг аймаг ИТХ санал оруулахаар зөвшилцөн төв зам дагуу тэмдэг тэмдэглэгээг сайжруулан нэмэгдэл тэмдэг тавьсан.

Тээврийн замын маршрут

Зураг 6



Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн замд хяналт тавьж маршрутын зөвшөөрөгдөх замаар хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангах тээвэрлэх зам дагуу гөлтгөнө асгахгүй байх олон салаа зам гаргахгүй байхад анхаарч хяналт тавьж ажилласан.



### 3. ЗХӨРС БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

- Замын хөдөлгөөн шатах тосох материал болон бүтээгдэхүүн тээвэрлэлтээс шалтгаалсан техникийн олон салаа зам үүсэж тоос шороо ихээр дэгдэж агаарын орчны хөрс ургамлыг бохирдуулах хөрсний гадаргад хуурай тоос шороон хучаас үүсгэх.
- Машин техникийн олон салаа зам үүсэж талбайн ургамлыг сүйтгэхээс хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулна. Хүнд даацын машин механизм, түүнийг тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах тослох материал нефтийн бүтээгдэхүүн асгарч хөрсөнд нэвчин хөрс бохирдуулж нөхцөл хэрэгжүүлсэн арга хэмжээ
- Асгарсан шатах тослох материалыг цэвэрлэх бохирдлоос салгах сургалт зохион байгуулсан
- Тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмжийн ажиллагааг тогтмол хяналт тавьж илэрсэн зөрчлийг цаг алдахгүй арилгаж арга хэмжээ авч ажилсан. Зарим техникийг шинчилэн засварласан
- Уурхайн зам арчилгаа усалгааг тогтмолжуулсан
- Замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулан авто машины хурдад хяналт тавьж ажилласан
- Санамсар болгоомжгүй байдлаас болж шатах тослох материал асгарсан зөрчил илэрхэд зөрчлийг цаг тухайд нь ахилгах

Зам талбайн тэмдэгжүүлэлт

Зураг 7



### 3. 4 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

- Уурхайн үерт орохоос хамгаалаж арга хэмжээ төслийн талбай хил дагуу 2244м урттай 1,0м өндөртэй шороон даланг үерийн усны хамгаалаж урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд байгуулсан.
- Худгийн ус бохирдохоос хамгаалах  
Төслийн талбай гүний худгийн трубаг 2м өндөрлөж хамгаалсан.  
Худгийн усыг байгалийн аргаар шүүх туршилт хийсэн.  
Цэвэршүүлэх шүүлтүүр хийсэн.
- Ширээ Уул 2 гөлтгөний ордын авто замын тоосжилтыг бууруулах нөхөн сэргээлт талбай шимт хөрсний овоолго  
Модны орчилгаа усалгаа  
Модны арчилгаа усалгааг төслийн талбайд байрлах худгаас хангадаг


Зураг 8




Уурхайн хил дагуу шороон далан



Үерт орох магадлалтай худга



Өндөрлөсөн худга



**2023 оны Усалгааны ерөнхий хуваарь**

Хугацаа	Эхний 10 хоног	Дунд 10 хоног	Сүүлийн 10хоног	Хариуцсан ажилтан
5 сар				Б.Баярсайхан
6 сар				Энхжаргал
8 сар				З.Баярсайхан
9 сар				Долгормаа
10 сар	Цэнэг усалгаа 2-3 удаа			С.Дэлгэрдалай

### 3.5 АМЬТАН УРГАМАЛД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Уурхайн ашиглалтын хугацаанд хүн машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн нэмэгдэх, уурхайн техник хэрэгслийн чичэргээ доргилтоос болж тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Иймд :

- Уурхайн үйл ажиллагаа зөв зохион байгуулалтай явуулахад анхаарч ажилласан
- Уурхайн дуу чимээг багасгах зорилгоор техник хэрэгсэлийн засвар үйлчилгээг шинчлэн хийсэн
- Ан амьтны судлан таниулах
- Хууль бус агнуур хийх амьтны үр зулзага үүр өндөгийг сүйтгэх зөрчил гаргахгүй байх талаар сургалт орсон тамдан судалгаа хийж зарим амьтны талаар ойлголттой болсон
- Олон салаа зам гаргахгүй тээврийн баталсан маршрутаар явуулсан
- Амьтаныг болзошгүй аюулаас сэргийлэх
- Төслийн талбайд ан амьтан орохоос урьчилан сэргийлэж далан хийсэн.

#### 4. Нөхөн сэргээлт

##### 4.1 Төслийн талбайд

Олборлох үйл ажиллагаанаас үүссэн 0,8 га талбайд дотоод овоолго 67,2 мян. м<sup>3</sup> дүүргэлтийг стандартын дагуу хийсэн

техникийн нөхөн сэргээлт

Зураг 9



4.2 Шимт хөрсний овоолгыг нөхөн сэргээлт Шимт хөрсний дүүргэлтийг 0,8 га талбайд 0,6 см зузаан тай 4,8 мян. м<sup>3</sup> хөрс тэгшилж таарсан. шимт хөрсний дэлгэлт тэгшилгээ стандартын дагуу хийсэн.

Биологийн нөхөн сэргээлт

4.3 0,2 га талбайд биологийн олон янзын нутгийн ургамалын үр болон шилжүүлгээр тана бударгана баглуур гэх мэт суулгасан. 0,2 га талбайд байгалийн олон янз ургамал тарисанаас нутгийн ургамал түлхүү ургамал дундаж өндөр нь 3-10 см өндөртэй ургамлын ургалт 70% байна.

Зураг 10



Хялгана, бударгана, баглуур түлхүү ургасан.  
0,2 га талбайд хармаг бут загны 500ш суулгаж усалгаа арчилгааг тогтмжуулсан  
түрүүчийн тарьсан улаан сухай ургалт сайн байгаа.

Зураг 11

Улаан сухай



Хармагын бут



Туулайн тор татсан



Моджуулалж байгаа талбайн торон хашааг туулай баг мал орохоос хамгаалаж давхар 400м  
туулайн тор нийтэд нь давхарлан хадсан усалгааны хэрэгсэлийг нэмэгдүүлсэн

## 5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ

### 5.1 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН СУДАЛГАА


Дүйцүүлэн хамгаалах газар нутгийн биологийн олон байдлын мониторинг судалгаа хийж тухайн нутаг дэвсгэрт бэлчдэг амьтадыг бүртгэн байршлыг тогоож цаашид хамгаалах шаардлагатай ажлыг зохион байгуулах үндсэн суурь мэдлэгтэй болох зорилгоор эхний ээлжинд тамдан судалгаа хийж гүйцэтгэв.

Судалгааны арга зүй тал хээрийн говийн бусад амьтаны судалгаа хийхэд хамгийн тохиромтой арга нь тамдан судлах арга барил. Энэ аргыг дүйцүүлэн хамгаалах судалгаанд ашиглах тамдан судалгааг ойролцоо толгод дэнж газрын байдалд тохируулан тодорхой маршрутын дагуу явж тааралдсан амьтдыг тоолж бүртгэхийг хэлнэ.

Дүйцүүлэн хамгаалах талбайн ойр орчим дахь туруутан болон жигүүртэн хэвлээр явагч амьтаны судалгааг хийх ажлыг 2023 оны 05 дугаар сараас 10 дугаар сарын хооронд нийт 3 удаа хийж гүйцэтгэсэн.

Тамдан судалгааны тойм зураг

Зураг 12



Судалгаанд онги голын зүүн талаас шорвогийн усны хяр баруун үзүүр хүртэл Дэлгэрхангай уулын урд бэлээс хул хайрхан хойд үзүүрт хүртэл Ойролцоогоор 30-50км зайд тамдан судалгаа хийсэн.

## 5.2 Зэрлэг амьтаны мониторинг судалгаа



**Баг:** Туруутан

**Овог:** Хөндий эвэртэн

**Төрөл:** Зээр

**Шинжлэх ухааны нэр:** Англи ухаа толгодоор идээшиж бэлчдэг. Зээрийн гол сүрэг Монгол байралдаг ба сибирийн өмнөд хэсгээр ба Хятадын зүүн хэсгээр бага зэрэг тархсан. Цагаан зээрийн монголд 1970-аад онд 5 сая цагаан зээр тоологдсон.

Харин 2010 оны тооллогоор зээр тоо толгой цөөрсөн тоологджээ. Хамаагүй хууль бус ангалтаас болж зээрийн сүрэг багассан байна. Зээр нь голцуу

20-30-аараа сүрэглэнэ зарим үед 5000 хүртэл тогойтоогоор сүрэглэнэ. Цагаан зээрийн эргэчин ооно, эмэгчин шаргачин, төлийг янзага, эргэчин шүдлэнг цэнхэр ооно, охин шүдлэнг зусаг шаргачин гэнэ. Голдуу хул шарга зүстэй, богино сүүлтэй, тангийхаа захаар шар хүрээтэй, шаргачин эвэргүй, ооно нь арагшаа тахийж үзүүр нь дотогш эргэн ойртсон шорон 2 эвэртэйгээр хар сүүлт зэргээс ялгаатай. Зургаадугаар сард янзаглана. Цагаан зээр хялгана, шаваг, хазаар өвс, үет ургамлаар хооллоно. Цагт дунджаар 70км хүртэл хурдална, цагаан зээр бүртгэгдсэн талбайн тэгш тал бүхий газрын эвдрэл, авто машины замын сүлжээ харьцангуй бага байв.

Орчны ажиглалт хийсэн. Тус цэгийн баруун хойд талд малчны бууц байсан. Трансекийн дагуу хөндлөн ажиглалт хийсэн ба тухайн талбайн гуу жалга гүвээ толгодтой. Гүвээ толгод бүхий хадархаг жижиг уулстай талбай сунган ажиглалт хийсэн боловч ойрхон малчны бууц, бэлчээрийн мал ихтэй байсан тул ан амьтан үзэгдээгүй.


Үүнд: Амьтад

- Мониторинг хийж гүйцэтгэсэн ажилтан нэр: Дэлгэрдалай
- Хугацаа: 2023. 06. 10-2023. 09. 30
- Мониторинг хийсэн тоо: 3
- Транекийн дугаар нэр :
- Нийт харсан амьтаны тоо: 58ш / давхардсан тооноор /
- Зүйлийн монгол нэршил : Цагаан зээр

### 5.3 Шувуудын мониторинг судалгаа

Тагтаа , хулан хороо, болжморын төрөл , болжмор, хог хэрээ ногтруу

Зураг 13



Дүйцүүлэн хамгаалах талбайд Тэдгээрийн дотор шавьж идэштэн туулайтан сарьсан далавчтан мэрэгч туруутан махан идэштэн гэх мэт тэмдэглэж байдаг.

### 5.4 Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт хамаарах гөлтгөний ордын талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Говь-Алтайн нурууны үргэлжлэл; хөрс-газарзүйн мужлалаар хойт говийн хөрсний мужид хамрагдана.

Судалгаанд хамрагдаж буй нутаг нь Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Олон нуурын хөндий болон Дорноговийн цөлөрхөг хээрийн тойргийн заагт оршдог.

Ургамалжилтын судалгаа явуулсны үндсэн дээр, энд тархсан ургамлын нөмрөгийг хэд хэдэн бүлгэмдэл болгов. Үүнд:

- Нам уулсын ухаа гүвээ толгодын сул хөгжилтэй бор хөрсөнд түгээмэл тархсан. Монгол өвс-хялганат бүлгэмдэл
- Нам уулс ухаа гүвээ толгодын хормой бэлийн сул хөгжилтэй арай бага чулуутай бор хөрсөнд түгээмэл тархдаг Хялгана-хазаар баглуур таана, хөмүүлт бүдгэмдэл
- Нам уулс ухаа гүвээ толгодын хоорондох тал хөндийн говийн бор хөрсөнд түгээмэл тархдаг Түжгэр баглуур, таана-хөмүүлт хазаар-хяганат бүлгэмдэл

Ургамлан нөмрөгийн ашиглалт, доройтлын өнөөгийн байдал


Төсөл хэрэгжих орчны нутаг дэвсгэрийн ургамалан бүрхэвч нь бага зэргийн элэгдэл эвдрэлд орсон байна. Энэ нь сүүлийн 3 жил гантай байсан мөн хүний хүчин зүйлээс болон энэ жил 7 сараас хойш 2-3 удаа бороо орсон. Зуншлаг тааруу тайлагдаж ургамлын ургалт муу байсан.

**кемп 1 цэгт** 1м<sup>2</sup> талбайд тамдан судалгаа 5 төрлийн 16-17 ургамал ургасан N 44 59 16. 5, E 104 20 13. 1

**Кемп 2 цэг** N 44 59 16. 3, E 104 20 14. 1 ургамал 5 төрөл

**Төслийн талбайд цэг 3** N 44 59 03. 6 , E 104 20 37. 5 5 төрлийн 24-26 ургамал

**Нөхөн сэргээлтийн талбай цэг 4** N 44 59 13,9 , E 104 20 32,6 4 төрлийн 14 ургамал



Тамдан судалгаанд ашгилсан техник хэрэгсэл

Бидний судалгаанд туруутан цагаан зээр , шувуунаас хулан жороо, хон хэрээ ногтруу, болжмор болон тагтааны зүйлийн ногтруу шувууд бүртгэгдсэн.

Туруутан : цагаан зээр

Махтан : үнэг хярс 3

Жигүүртэн: Хулан жороо 6, Хон хэрээ 3 ногтруу3 сүрэг тагтаа 2 сүрэг, болжморийн 3 төрлийн

Шавьж идэштэн: Дэлдэн зараа 1 бүл

Хэвлээр явагч: Хонин гүрвэл, могойн гүрвэл


Туулайтан: Бор туулай 5 бүртэгдсэн.

Уурхайн талбайг ургамлын байдал



Ширээ Уул 2 гөлтгөний ордын ургамлын өнөөгийн байдал

Диаграмм № 1. ургамлын зүйлээс Бударгана-39 %, Хялгана-17 %, Баглуур-6 %, Таана 18 %, Өмхий өвс 10 %, Орог тэсэг 6 %, Өргөст ортууз 2 %, Хазаар өвс 1 %, Шарилж 1 % эзэлсэн байна. Зонхилох ургамал нь Бударгана



Диаграмм № 2. ургамлын зүйлээс Таана, Хялгана тус тус зонхилож байна.

**Дүгнэлт:** Ургамлын мониторингийн судалгаа явуулахад тухайн жилийн цаг уурын нөхцөл байдлаас хамаарч ургамлын бүрхэц, ургалтын хугацаа нь өөр өөр байна. Энэ жил хур тунадас багатай гантай байсан учир ургамлын мониторингийн судалгаагаар хагдарсан бүрхэц тодорхойлход хүндрэлтэй байсан. Харин 9-р сарын ургамлын мониторингоор цэгүүдийн ургамал ургалт нь харцангуй сайн байсан.

## 6. Хог хаягдлын менежмент

Энэхүү ажлын үр дүнгээр хог төслөөс үүсч буй хаягдлын бүтцийн судалгааг хийж байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоон үнэлж, сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, улмаар хамгийн бага түвшинд хүртэл бууруулах, арилгахад чиглэсэн арга хэмжээний зөвлөмжийг Монгол улсын улсын стандарт, норм нормативд заасан шаардлагын дагуу тусгасан. , ажилтнуудад хог хаягдлын чиглэлээр сургалт явуулсан болно.

Зөвлөх үйлчилгээгээр тогтоогдсон сайжруулах арга хэмжээ, зөвлөмж зэргийг үндэслэн уурхайн хэмжээнд дахивар болон аюултай хог хаягдлын ангилан ялгалтыг сайжруулж, дахин боловсруулах үйлдвэрт хүргэх арга хэмжээг авч ажиллаж байна. Сар бүр байгаль орчны чиглэлээр хийгдэж буй ажлын явцад хяналт тавьж, зөрчил илэрсэн тохиолдолд хариу арга хэмжээг яаралтай авч ажилладаг ба хог хаягдлыг зориулалтын цэгт хүргэх, дахин боловсруулах үйлдвэр, ААНБ-д нийлүүлсэн

### 6.1 ЭНГИЙН БОЛОН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН МЭДЭЭЛЛИЙН САН ҮҮСГЭХ

- Энгийн хог хаягдлыг ангилан ялгаж гэрээний дагуу устгах
- Хог хаягдлын журамд тусгаж аюултай хог хаягдлыг бүртгэжүүлэн мэдээлэлийн сантай болсон
- Цэвэрлэгээний хувиар гаргаж хяналт тавьж хотхон уурхай цэвэрлэгээг тогтмолжуулан үр дүнд хүрсэн
- Бүтээгдэхүүн тээвэрлэх технологийн зам дагуу хамтарсан хийтийн цэвэрлэгээ хийхэд хүн хүч машин техникийн туслалцаа үзүүлсэн
- Технологийн зам дагуу үер усанд эвдэрсэн талбайг дүүргэлт хийж тэгшилсэн.

Компанийн үйл ажиллагаанаас үүсч буй энгийн, аюултай хог хаягдлын бүртгэлийн нэгдсэн маягтыг боловсруулж Хог хаягдлын журманд тусган бүртгэл өдөр хөтөлж байна.

### 6.2 ХОГ ХАЯГДЛЫН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ЗУРАГ

Уурхайн хог хаягдлын цэвэрлэгээний бүсчлэлийг ажилчдын хотхон, уурхай гэсэн 2 хэсэгт хувааж Хог хаягдлын цэвэрлэх нь үр дүнтэй зохион байгуулахад чухал ач холбогдолтой ажил болсон.



### 6.3 АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, Аюултай хог хаягдлыг шилжүүлэх гэрээг “Эко” ХХК-тай байгуулсан.

### 6.4 АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ЖАГСААЛТ ГАРГАЖ, ХОР АЮУЛЫН ЗЭРЭГЛЭЛ, АНГИЛЛЫН КОДООР ТӨРӨЛЖҮҮЛЭХ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 12 -ны өдрийн А/349 дугаар тушаалаар батлагдсан “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл”-д заасны дагуу уурхайн үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдлын нэр төрлийг бүртгэлжүүлэн, хор аюулын зэрэглэлээр нь кодолж мэдээллийн сан үүсгэсэн.

Аюултай хог хаягдлыг төрөлжүүлэн мэдээлэлийн санд оруулсан

Д/Д	Нэр төрөл	Тоо хэмжээ	хадгалалт	тайлбар
1	Акумлятор батерей	12ш хуруу зай	Аюултай хог хаягдын цэг	Акумлятор гараагүй
2	дугуй	5	Уурхайн талбай	Хашлага ашигласан
3	Ашигласан шингэн	477л	Аюултай хог хаягдлын цэгт	Битүү саванд
4	лампа	3ш	Аюултай хог хаягдлын цэгт	Битүү саванд

## 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

### Археологийн олдворууд ба түүх, соёлын дурсгалт зүйлс, тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөө

Төсөл хэрэгжих орчны газрын ойролцоо түүх соёлын дурсгалт зүйлс одоогоор илрээгүй байгаа бөгөөд хэрвээ илэрвэл тэр даруйд холбогдох байгууллагад мэдээлэх үүрэгтэй. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт Дэлгэрхангай уулын байгалийн нөөц газар улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд багтдаг.

## 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

8.1 Хөдөлмөр хамгаалалын эрүүл ахуйн хэрэгжилт эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж ажлын хувцас хэрэгсэлээр хангасан

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа зөвлөгөө сургалт явуулах гарын авлага материал танилцуулсан

Аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан

Химийн бодисын шинж чанар, ашиглалт,

Химийн бодистой харьцаж ажилладаг ажилтнуудад сургалт Аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулж ойлголт мэдэгдэхүүнтэй болгосон.

Тайлант онд 10 гаруй ажилтанд сургалт зохион байгуулсан

Уурхайд байрлах ШТС-дын аюулгүй ажиллагааг хангах үүднээс үерийн хамгаалалтын шороон даланг 1 метрийн өндөртэй байгуулсан.

### 8.2 ХАЛМ-ИЙГ ЗОХИХ ГАЗРУУДАД БАЙРШУУЛАХ

Засварын ажилд түгээмэл хэрэглэгдэж буй бараа материалын судлан химийн бодисын хор аюулын лавлах мэдээллийг боловсруулж зохих хэсэгт байршуулсан. Ажил хүлээлцэх байр, засварын газар, агуулах зэрэгт байршуулсан



ХАЛМ-ийг шаардлагатай газруудад байршуулсан байдал *Зураг № 16.*

### 8.3 ХИМИЙН БОДИСЫН ШИНЖ ЧАНАР, АШИГЛАЛТ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ

Уурхайн үйл ажиллагааны явцад цэвэр уснаас бусад бүх төрлийн шингэн бодис болон химийн хортой нэгдэл агуулсан бодис, эдгээр бодисуудыг найрлагандаа агуулсан материал зөвшөөрөгдөөгүй газар, орчинд хэмжээ харгалзахгүйгээр агуулсан савнаас халих, асгарах, хаягдах тохиолдолд Монгол улсын хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт-ууд мөн компанийн Асгаралтын үед авах арга хэмжээ авах журмын дагуу төслийн хүрээнд сахин мөрддөг.

Уурхайд ашиглаж буй химийн бодисын найрлага бүхий бүтээгдэхүүн, тэдгээрийн шинж чанарын талаарх сургалтыг зорилтот, нэгжийн ажилтнуудад сургалтаар дамжуулан мэдээлэл өгсөн.

Тайлант онд давхардсан тоогоор 25 ажилтан уг сургалтанд хамрагдсан.

“Химийн бодисын аюулгүй байдал, хор аюулын лавлах мэдээлэлтэй танилцах” сэдвийн хүрээнд уурхайн засварын хэсэгт ажиллаж байгаа бүх ажилчдад давтан зааварчилгаа танилцуулаж дадлагжуулдаг.



Зураг 17. химийн бодис, аюулгүй ажиллагааны талаар сургалт дадлага хийж буй байдал

### 8.4 АСГАРАЛТААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, АСГАРАЛТЫН ҮЕД АВАХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

“Ширээ уул” 2гэлтгөнө ордын ил уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2023 оны 02-р сарын 18-ны өдөр ОБЕГ-ын дэргэдэх уул уурхайн аврах ангийн захирагч, хурандаа Гантулга батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Мөн 2023 оны 08-р сарын 15-ны өдрийн захирлын 2023/16 тоот тушаалаар “Асгаралтын журам”-ыг батлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Асгаралтын үед ашиглах иж бүрдлийг үйлдвэр, техникийн засвар үйлчилгээний хэсэгт байршуулсан. Үүнд:

- Арчих материалыг битүү саванд хадгалах
- Хуурай элс, үртэс
- Шингэгч материал/дэр/
- Хувин сав
- Хүрз
- гар хамгаалах зузаан резинин Бээлий тосгуур шүүр

Зураг 18



### 9. Орчин хяналт шинжилгээ

## 9.1 Агаарын шинжилгээ

Агаарын тоосонцорын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байна. Төслийн талбай болон хотхоны орчны тоосжилт үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас агаар цацагдаж буй тоосон цорен дэгдэлтийг шилжүүлсэн.

## 9.2 ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг болох орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт хүрээнд хяналт тавьж ажиллаж шинжилгээ хийлгэж байна.

### Орчны хяналт шинжилгээ хөрсөн бүрхэвчийн орчим

хөрсний хяналтын цэгүүдээс байгаль орчны мэргэжилтнүүд зориулалтын дээжний саванд хөрсний дээж авч шинжилгээнд явуулсан.

2023 оны 09-р сарын 28-ны өдөр хөрсний 7 дээжинд хүнд металл тодорхойлох шинжилгээ хөрсний цэгүүдээс дээж авч дараах шинжилгээг хийлгэсэн. Үүнд:

- Уурхайн болон хотхоны хөрснөөс шилжүүлсэн.
- Хөрсний 7 дээжинд химийн задлан шинжилгээ
  - Хөрсний 7 дээжинд механик бүрэлдэхүүн тодорхойлох шинжилгээ
  - Хөрсний 7 дээжинд хүнд металл тодорхойлох шинжилгээ
- Усан орчим

9.3 Уурхайн цэвэр усны болон бохир хяналтын цэгээс / Уур амьсгал өөрчлөлтийн судалгаа хамтын ажиллагааны төвд усны / дээж шинэчлүүлсэн. Үүнд:

- Усны химийн шинжилгээ
- Цэвэр усны микро биологи
- Бохир усны химийн шинэжилгээ
- Хүнд метал /Бохир ус /
- Бохир усны нян судлал шижилгээ
- Усны хорт элемент нэгдлийн шинэжилгээ
- Цэвэр болон бохир ус

Уурхайн цэвэр усны шинжилгээнд Цаг уур орчны шинжилгээний газар Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори хийлгэсэн усны шижилгээ нь  
2023. 04. 24 - 2023. 08. 29

Огноо	Сорьцын нэр	PH	ЕС	SO4 МГ Л	Сl	Ca	Mg	Na+K	NCO		
2023. 04. 24	Ширээ Уул 2 ордын ус	8. 06	2780	1166	135	526	53. 3	54. 2	290	224	30. 65
		7. 74	10320	2267	2155	537	125	1880	259	7223	37. 04
2023. 08. 09	Тарагтын худаг	8. 44	801	128	114	559	12. 5	147	234	691	3. 82
2023. 04. 24	MNS 0900:2018	6. 5-8. 5	1000	500	350	100	30				7. 0

Уурхайн худагны цахилгаан дамжуулалт 2,8-10,3 дахин их эрдэсжилт өндөртэй, хатуулаг 4,4-5,3 дахин их байгаа тул ундны зориулалтаар ашиглаж болохгүй.

Цэвэр усыг байгалийн аргаар цэвэршүүлэхэд зарим үзүүлэлт буурч байгаа боловч хараахан ундны хэрэгцээг хангахгүй байна.

Цаашид ундны хэрэгцээнд ашиглахын тулд цэвэр усны шүүлтүүр судлаж байна.

## 10. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах нь БОМТ–ний хэрэгжилтийн баталгааг бий болгож буй хэлбэр гэж үзэж ихээхэн ач холбогдол өгөх ёстой. БОМТ-ний хэрэгжилтийг хангахад зөвхөн байгаль орчны мэргэжилтэн бус бусад нэгжийн ажилтнууд болоод сумын иргэд, албан хаагч нарын оролцоо шаардагддаг. Тус төлөвлөгөөгөөр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд оролцооны хэлбэрийг тодорхойлон хэрэгжилтийг хангах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байгаа юм.

2023 онд өгсөн зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлууд

*Хүснэгт № 4. Зөвлөмжийн дагуу хийдсэн ажлууд*

Д/д	Зөвлөмжинд тусгагдсан ажлууд	Хэрэгжилт
1	Уурхайн баримт бичгийн бүрдэлт	Ус хогийн гэрээг Дэлгэрхангай сумын Засаг даргатай байгууллаж гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ус, хог, газрын гэрээ байгууллаж төлбөр төлсөн Дунговь аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулсан
2	Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх хамгаалах	Үерийн гамшигаас хамгаалаж Төслийн талбайд хил дагуу 2244м урттай үерийн хамгаалалтын далан байгуулав.
3	Шимт хөрсний овоолго	Ашиглалтын үйл ажиллагааны явцад үүссэн шимт хөрсний овоолгыг хурааж хэлбэржүүлэж усалгаажуулан тэмдэгжүүлэн.
4	Ашиглалтын талбай нь аюулгүй ажиллагааг хангах	Осол эрсдэлээс хамгаалан уурхайн аюулгүй ажиллагаа хангахын тулд ашиглалт явуулаж буй талбайд хашилт хийж тэмдэгжүүлэв.
5	Техникийн нөхөн сэргээлтийн талбайг ургамжуулах	Техникийн нөхөн сэргээлт 0,8 га талбайд дотоод овоолго дүүргэлт хийсэн Шимт хөрсийг 0,8 га талбайд дэлгэсэн тэгшилсэн. Биологийн нөхөн сэргээлт 0,4 га талбайд ургамжуулав. Цаашид усалгааны сайжруулах 500ш хармагын бут тарьсан
6	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажил	Зэрлэг амьтад шувуунд ургамалд мониторинг хийх, биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх чиглэлд судалгаа хийсэн Зэрлэг амьтан цагаан зээр , хар сүүлт, хярс, шувууд, иүүдлийн шувуу, суурин шувуу Ургамалын төрөл зүйлд тамдан туршилтыг судалгааны ажил хийв..
7	Ойролцоо зам талбай хөрсний эвдрэлийг дүйцүүлэн хамгаалах ажил	Үерийн усанд эвдэрсэн гуу жалга дүүргэлт хийж тэгшилсэн зам дагуу асгарсан гөлтгөнө цэвэрлэхэд техник хүн хүч гарган оролцсон. Тээврийн жолооч нарт замын хөдөлгөөний дүрмийн дагуу батлагдсан маршрутын дагуу тээвэр хийхэд хяналт тавьж ажилсан
8	Хог хаягдлыг ангилах Тусгай цэгтэй болох	Хогийн төрөлжүүлэн ангилах талаар ажилчдад сургалт орсон Хогоо ангилан ялгаж нийтийн цэвэрлэгээг хуваарьт хяналт тавьж ажилласан. Сумын 2-р багийн олон нийтийн хүсэлтийн дагуу тээврийн замд нийтийн цэвэрлэгээ хийсэн

9	Аюултай хог хаягдлыг коджуулан төрөлжүүлэх	Аюултай хог хаягдал төрөлжүүлэн, коджуулан бүртгэлжүүлэж тусгай цэгт хадгалсан. Аюултай хог хаягдлын цэгийн тохижуулсан
10	Дотоод хяналт сайжруулах үйл ажиллагаанд дотоод хяналтыг тогтмол хийж, илэрсэн зөрчлийг тухай бүрт таслан зогсоож арилгуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх.	Дотоод хяналт шалгалтын тогтмол хийж илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулаж хяналт тавин ажиллав. Асгаралтын иж бүрдэл Галын аюулгүй ажиллагааны самбар болон сарааг тохижуулсан Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу тавих хяналтыг сайжруулах ажлыг төлөвлөн байгаль орчны чиглэлээр хийгдэх ажлын хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Мөн сар бүр ажлын байрны анхан шатны үзлэгээр ХАБЭА, мэргэжилтэн хяналт тавьж, үзлэгээр зөрчлийг арилгуулах талаар шаардлага тавьж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилсан.
11	Биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр санаачлага гарган ажиллах, нутгийн унаган ургамлыг биологийн нөхөн сэргээлтэнд ашиглах	Биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр нутгийн унаган ургамлын үрээр болон үрсэлгээгээр тариж ургуулах туршилд судалгаа хийж, цаашид нутгийн ургамлын үрийн сантай болох зорилт тавьж ажиллаж байна.
12	ОХШХ-ийн дагуу хийгдэх ажилд орон нутгийн иргэдийн оролцоог хангах, байгаль хамгаалах ажлын мэдээллийг олон нийтэд мэдээлэх, мэдээллийг иргэдэд хүргээмжтэй хүргэх арга ажлыг үр дүнтэй зохион байгуулах.	Агаар, хөрс, усны дээжийг орон нутгийн иргэдийг байлцуулсан шинжүүлсэн Баг болон сумын иргэдэд уурхайн үйл ажиллагаатай танилцуулаж тайлан тавьсан.
13	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд тарьсан 500 модны усалгаа арчилгааг тогтмол хийж ургалтын хувийг нэмэгдүүлэх.	Түрүү тарьсан мод 90% ургалтай байна. 500ш хармагны бут тарьсан. Усалгааг сайжруулаж ургалт арчилгаанд анхаарч ажиллав.



Удирдлага зохион байгуулалт

Зураг 19



## 10.1 ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Оршин суугч, оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Хугацаа	Зохион байгуулах газар	Тайлбар
1	Орон нутгийн удирдлага, ИТХ, Байгаль хамгаалагч	Уулзалт	Батлагдсан төлөвлөгөөг танилцуулах	II сар	Сумын ЗДТГ	Танилцуулсан
2	Дэлгэрхангай сумын 2-р багийн иргэд малчид	Танилцуулга	БОМТ-ийн хэрэгжилтийн явцыг танилцуулах	9 сар	Сумын соёлын төвд	Танилцуулсан
3	Дэлгэрхангай сумын иргэд, удирдлагууд	Хэлэлцүүлэг	БОМТ-ийн хэрэгжилтийг танилцуулах.	XI сар	Сумын ЗДТГ	Танилцуулсан
4	Дэлгэрхангай сумын иргэд	Хэмжилт, судалгаанд оролцуулах	БО-ны хэмжилт судалгаанд олон нийтийн оролцоог хангах	Жилийн турш	Уурхай орчмын мониторингийн цэгүүдэд	Иргэдийн төлөөлөл оролцсон

## 10.2 БОМТ-НИЙ ЗАРДАЛ

д/д	Үйл ажиллагааны чиглэл	Төлөвлөсөн төсөв /мян. ₮/	Зарцуулсан хөрөнгө /мян. ₮/
1	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	13,25	17,0
2	Нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа	5,55	6,0
3	Зохион байгуулалтын төлөвлөгөө	1,5	2,0
4	ОХШХөтөлбөр	1,2	1,0
5	Хог хаягдлын менежмент	1,0	1,0
6	Соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-	-
7	Орон нутагт тайлагнах төлөвлөгөө	2,0	20,5
8	Осол эрсдэлийн менежмент	2,6	2,1
9	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	35	2,0
Нийт		30,6	51,6

## 11. БОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙН ДҮН

Ангилал	Бүлэг	Арга хэмжээ	Биелэлтийн шалгуур	Биелэлт	Эзлэх жин	Хувь %
Сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа: Агаарын чанар	11. 1. 1	Уурхай, хотхонд тоос болон тоосонцорын үзүүлэлтүүдийн түвшинг тодорхой н цэгүүдэд хэмжилт хийнэ.	Төслийн 31,98 га талбайд хийсэн шинжилгээ	Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хөрс хуулалт авто машины хөдөлгөөн болон үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх тоосонцорын хэмжээг бууруулахад усалгаа хийж, авто тээврийн хурданд хяналт тавьж ажилсан. Агаарын шинжилгээ хийлгэж хяналт тавьж ажилласан Тээврийн хэрэгсэлийн үзлэгт хамруулсан оншилгоо роуулсан. Засвар үйлчилгээ тогтмол хяналт тавьж гарсан зөрчлийг арилгуулаж хяналт тавьж ажилласан.	5	100%
	11. 1. 2	Тоосжилт бууруулах зорилгоор уурхайн технологийн зам болон уурхай хотхон хоорондын замын усалгаа арчилгааг хийж, эргэл бүхий хэсэгт замд хяналт тавих	Замыг цэгцэлж тэмдэгжүүлэн замын эргэдтийг янзалах	батласан хуваарийн дагуу уурхайн дотор болон технологийн зам хотхон хоорондын замд хяналт тавин шинээр орсон ажилтанд замын хөдөлгөөн болон маршрутын дагуу явах сургалт орж хөдөлгөөнд оролцоход хяналт тавьж усалгаа арчилгаа хийж байна. Замын эргэлтийн түйрэн ихтэй хэсгийн хусаж тэгшлэн усалгаажуулсан.	15	100%
	<b>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа</b>					<b>20</b>
Сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа: Хөрсөн орчин	11. 2. 1	Хөдөлгөөн ихтэй замуудын маршрут гаргаж батлуулах	Замын батлагдсан маршрут	Тусгай зөвшөөрлийн талбайн хил доторх замыг тэмдэгжүүлэн, холбогдох дүрэм журмын талаар шинээр ажилд орж байгаа ажилчдад тухай бүр сургалт ордог. Тус сургалтанд суусан ажиллагсад уурхай руу зорчихдоо тогтсон маршрутын дагуу замын хөдөлгөөнд оролцдог. уурхай-кемп хоорондох зорчихдоо хөдөлгөөн аюулгүй ажиллагааг хангаж оролцогдов.	10	100%
	11. 2. 2	Шимт хөрсийг тусгайлан хурааж усалгаажуулах	Хөрсийг хэлбэржүүлэн овоолох усалах	Хөрсийг нягтаршуулан хэлбэржүүлэн овоолсон тоосжилт босохоос хамгаалаж усалгаажуулдаг	10	100%

Ангилал	Бүлэг	Арга хэмжээ	Биелэлтийн шалгуур	Биелэлт	Эзлэх жин	Хувь %
	11. 2. 3	Асгаралт үүсч болзошгүй газруудад асгаралтын иж бүрдлийг байршуулах. /засварын газар, түлш цэнэглэх талбай Байршуулах/	Асгаралтын бүртгэл, хариу арга хэмжээний асгаралтын иж бүрдлийн бэлэн байдлыг хангах	Ахуйн болон аюултай хог хаягдлын сөрөг нөлөөллийг багасгахын тулд үйл ажиллагааны улмаас үүсэж буй хог хаягдлыг ангилан ялгаж зориулалтын талбайд цуглуулан, эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан хаяж устгаж байна. Мөн 7 хоног бүр анхан шатны үзлэгийг тогтмол хийж илэрсэн зөрчлийг тухай бүрт нь арилгуулах арга хэмжээг тогтмол авч зөрчилийг арилгасан хэрэгжүүлэн ажиллаж байна. захирлын 2023. 08. 15-ны өдрөөр батлагдсан “Асгаралтын журам”-ын дагуу асгаралт болсон тохиолдолд мэдээллийн санд бүртгэлжүүлж, хариу арга хэмжээ авч авах урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах. Одоогоор асгаралт бүртгэгдээгүй	20	100%
	11. 2. 4	Олон салаа замыг арилгах	Эвдэрсэн зам харгуй засах	Гэлтгөнө тээврийн шороон замд үерийн усанд эвдэрч гуу жалга гаргасыг дүүргэлт хийж тэгшилэн засаж ажил хийгдсэн салаа зам гарцаас хамгаалан нөхцөлийг бүрдүүлсэн. Газрын гэрээ байгуулаж гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	10	100%
	<b>Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа</b>					<b>50</b>
Сөрөг нөлөөллийг бууруулах ажиллагаа: Усан орчин	11. 3. 1	Байгалийн гамшиг үер уснаас хамгаалах	Үерээс хамгаалсан далан	Уурхайн усанд автах мал амьтан уурхайн ухаш нүхэнд унахаас хамгаалаж Төслийн талбайн хил дагуу/ 2244 м талбай 0,8м өндөр / үерийн хамгаалалт далан байгуулсан.	10	100%
	11. 3. 2	Ус бохирдохоос сэргийлэх хамгаалах	Гүний худгийн үерийн уснаас хамгаалах	Төслийн талбайд байгуулсан гүний худгийн труба 2 м өндөрлөж үерийн уснаас хамгаалав. Талбайг тэгшлэн өндөрлөсөн усны хатуулга бууруулах туршилт судалгаа хийсэн. Усны шинжилгээ хавмаргав.	10	100%

Ангилал	Бүлэг	Арга хэмжээ	Биелэлтийн шалгуур	Биелэлт	Эзлэх жин	Хувь %
	11.3.3	ШТС тээврийн хэрэгслүүдийн болж хөрс бохирдох Шатах тослох материалаас ус бохирдох	Ус бохирдох нөхцөл хаах хамгаалах	Үерийн ус болон асгралтаас болж хөрс ус бохирдохоос урьдчилан сэргийлэж асгаралтын иж бүрдэл байршуулах анхан шатны хяналтыг тогтмол тавьж ажиллав. Одоогоор усан орчимд бохирдоогүй.	10	100%
<b>Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа</b>					<b>30</b>	<b>100%</b>
Сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа: Биологийн олон янз ургамал	11.4.1	Уурхайн талбайн ойролцоох Амьтан судалгаа Төслийн талбайн ойролцоо амьтад	Төслийн талбайд болон ойролцоо орчин хамрагдсан	Онги голоос зүүн тийш Шорвогийн усны хяр Хойд тал Дэлгэрхангай уулаас хул хайрхан хүртэл нутагт ажиглалт хийсэн. 2023. 05 сараас 10 сар хүртэл хугацаанд Туруутан 1 төрөл, туулайтан 1 төрөл махтан 1 төрөл, шавьж идэштэн 1 төрөл, хэвлээр явагч 1 төрөл бүртгэсэн	10	100%
	11.4.2	Шувуудын судалгаа	Төслийн талбайн ойролцоо	Нутгийн онцлогт дасан зохицож амьдардаг шувуудын тамдан судалгаанд хон хэрээ, тагтаа, хээрийн болжмор хулан жороо зэрэг шувууд бүртгэгдсэн тагтаа 1 төрөл, хэрээ 1 төрөл болжмор 1 төрөл, ногторуу 1 төрөл, нүүдлийн шувуу 2 төрөл бүртгэсэн	10	100%
<b>Биологийн олон янз байдалд сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа</b>					<b>20</b>	<b>100%</b>
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	11.5.1	техникийн нөхөн сэргээлт	техникийн нөхөн сэргээлт хийсэн.	Төслийн талбайд дотоод овоолго 0,8 га-д 67,2мян. м3 техникийн нөхөн сэргээлтийг шаардлага ханган стандартын дагуу хийв. Техникийн нөхөн сэргээлтийг сумын байгаль орчны байцаагч болон комиссын гишүүдэд танилцуулав..	35	100%

Ангилал	Бүлэг	Арга хэмжээ	Биелэлтийн шалгуур	Биелэлт	Эзлэх жин	Хувь %
	11. 5. 2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний овоолгын нөхөн сэргээлт	0,6 см зузаантай 4,8 мян.. м3 шимт хөрс овоолго тэгшилсэн хучив. 0,2 га-д талбайд нутгийн олон янзын ургамлыг үрээр болон үрсэлгээгээр шилжүүлэн суулгасан /Бударгана баглуур хялгана , тана гэх мэт арчилгаа усалгааг тогмолжуулав. /	35	100%
	11. 5. 3	Модлог ургамлын тарих	Хармаг заг тарих	Нөхөн сэргээлтийн туршилтын талбайд улаан сухай амжилттай ургуулсан. БОМТ-ийн дагуу, 500 ш хармагны бут, заг тариалан, усалгаа арчилгааны хуваарь гарган ажиллаж байна. Усалгааны нөөцийн савыг нэмэгдүүлсэн Хашааны торыг янзалан нэмэлтээр доогуур нь туулай баг малаа орохоос хамгаалаж600м тор давхарлаж татсан	30	100%
	<b>Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө</b>				<b>100</b>	<b>100%</b>
Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө	11. 6. 1	Амьтан ургамлын судалгаа		Тамдан судалгааны аргаар мониторинг судалгаанд явуулахад туурайтан, хар сүүлт ажиглагдаагүй цагаан зээрийн 6-7 бүлтэй 4 сүрэг таарсан. Махчин үнэг хярс 3ш үнэг хярс бүртгэсэн. Чоно таараагүй Жигүүртэн нүүдлийн шувуу халбаган хошуу 2 тогруу 1 бүртгэсэн. Нутгийн шувуудаас хулан жороо 6 , тагтаа 2 сүрэг, ногтруу 3сүрэг, болжмор ,хон хэрээ зэрэг амьтад хамрагдсан Дэлдэн зараа 1 бүл ,туулай, 5 алаг даахай бүртгэсэн хэвлээр явагч2 төрлийн гүрвэл бүртгэгдсэн/ хонин, могой/ Судалгааны ажлыг 2023 оны 05 сараас 10 сар хүртэл хугацаанд хийв.	50	100%

Ангилал	Бүлэг	Арга хэмжээ	Биелэлтийн шалгуур	Биелэлт	Эзлэх жин	Хувь %
	11. 6. 2	Үер уснаас болж эвдэрсэн газрыг сэргээх	Шороон зам засах	Замын ховил гуу жалгыг дүүргэлт хийж тэгшилж олон салаа зам гарахаас хамгаалах Зам зассан координат N 45 01 36. 5 E 104 24 50. 8 N 45 01 38. 6 E 104 24 50. 8	50	100%
	<b>Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө</b>				100	100%
Түүх соёлын өвийг хамгаалах	11. 7. 1	Палентлогийн Археологийн хайгуул, судалгаа		Архелогийн палентлогийн хайгуулын судалгаагаар олдвор илрээгүй Үйл ажиллагааны явцад ямар нэг зүйл илрээгүй. Шинээр ажилд орсон ажилтанд архелогийн полентлогийн талаар олвор илэрсэн тохиолдолд ямар арга хэмжээ авах талаар сургалт орсон.	10	100%
	<b>Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө</b>				10	100%
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	11. 8. 1	Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах	Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө	Аюул ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу эрүүл мэндийн урьчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан. Ажлын хувцас хэрэгсэлээр хангасан. Ослын үед ажиллах мэдлэгийг сайжлуулах сургалт зохион байгуулсан. Галын самбар хор багс хэрэгсэлээр хангасан	10	100%
	11. 8. 2	Химийн бодисын шинж чанар, ашиглалт, аюулгүй ажиллагааны талаар	ажилтанд сургалт, суртчилгаа явуулах.	Химийн бодистой харьцаж ажилладаг ажилтнуудад практик сургалт зохион байгуулж ойлголт мэдэгдэхүүнтэй болгосон. Давхардсан тоогоор 10 удаа сургалт зохион байгуулсан.	20	100%
	11. 8. 3	ШТС-ын ойролцоо үерийн хамгаалалт хийх	Үерийн далан байгуулах.	уурхайд байрлах ШТС-дын аюулгүй ажиллагааг хангах үүднээс үерийн хамгаалалтын шороон даланг 1 метрийн өндөртэй байгуулсан.	20	100%

Ангилал	Бүлэг	Арга хэмжээ	Биелэлтийн шалгуур	Биелэлт	Эзлэх жин	Хувь %
<b>Осол эрдэлийн менежментийн төлөвлөгөө</b>					<b>50</b>	<b>100%</b>
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	11. 9. 1	Аюултай хог хаягдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, хяналтыг сайжруулах	Аюултай хогын цэг байгуулж тохижуулах	“Аюултай хог хаягдлын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх” Зөвлөмжийн дагуу Аюултай хог хаягдлыг коджуулан бүртгэл хөтөлсөн хаягжуулсан. Аюултай хог хаягдлын цэгийг тохижуулсан	10	100%
	11. 9. 2	Одоо болон ирээдүйд гарах хог хаягдлын хэмжээг уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан тооцох, ордын хэмжээнд хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах	Гэрээний хэрэгжилт, гарсан үр дүн	2023 оны төсөвт үйл ажиллагаанаас гарах хог хаягдал ангилан ялгах төрөлжүүлсэн. Хогийн гэрээ байгуулаж гэрээний нөхцөлийг ханган ажилласан	10	100%
	11. 9. 3	Хог хаягдлын гарц, ангилан ялгалт, төлбөрийг хянах зорилгоор хог хаягдлын мэдээг бүртгэлжүүлж, мэдээллийн сан үүсгэх	Нийт хог хаягдлын бүртгэлийн мэдээлэл сантай болох	Энгийн, аюултай хог хаягдлын хаягжуулан бүртгэсэн. Хог хаягдлын журманд тусгасан хог хаягдлын зөрчлийг танилцуулав.	10	100%
	11. 9. 4	Бүх нийтийн их цэвэрлэгээг тогтмол хугацаанд зохион байгуулах	Зам дагуу гөлтгөнө цэвэрлэх	нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж хүн хүч, техник хэрэгслээр дэмжлэг туслалцаа үзүүлсэн. Цэвэрлэгээнээс гарсан гөлтгөнийг өөрийн уурхайд буулгасан	20	100%
	11. 9. 5	аюултай хог хаягдал нийлүүлэх гэрээ байгуулах	Хүлээн авагчтай гэрээ байгуулсан,	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, Аюултай хог хаягдлыг шилжүүлэх гэрээг “Ган Эко Жигүүр” ХХК-тай байгуулсан.	10	100%
	11. 9. 6	Аюултай хог хаягдлын жагсаалт гаргаж, хор аюулын зэрэглэл, ангиллын кодоор төрөлжүүлэх	Мэдээллийн сан үүсгэсэн байдал	Уурхайн үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдлын нэр төрлийг бүртгэлжүүлэн, хор аюулын зэрэглэлээр нь кодолж мэдээллийн сан үүсгэсэн.	10	100%
	<b>Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө</b>					<b>50</b>
Орчны хяналт шинжи	12. 1. 1	Тоосонцорын агууламжийн хэмжилт	Хэмжилт хийх	Тоосонцорын шинжилгээ хийлгэсэн тоосонцор зөвшөөргдсөн хэмжээнээс хэтрэхгүй хэвийн	10	100%
	12. 1.	Цэвэр усны чанарын шинжилгээ	Усны	Уурхайн худгийн уснаас дээж авч итгэмжлэгдсэн	10	100%



Ангилал	Бүлэг	Арга хэмжээ	Биелэлтийн шалгуур	Биелэлт	Эзлэх жин	Хувь %
	2		шинжилгээнд хамруулсан	лабораторид тогтмол шинжлүүлэж Усны мониторинг судалгаа хийсэн. Хатуулаг өндөр учир унданд хэрэглэхгүй.		
	12. 1. 3	цэвэршүүлсэн бохир усны хяналт	шинжилгээнд хамруулсан	бохир ус буюу цэвэрлэх байгууламжаас гарсан саарал уснаас дээж авч шинжилгээний лабораторид шинжлүүлээд байна.	10	100%
Ургамлын мониторинг	12. 1. 4	Трансектийн дагуу талбайд ургамлын хяналт явуулах	Ургамлын мониторинг судалгаа	2023 оноос төслийн талбайд ургамалжилтын үндсэн бүлгэмдлүүдийг илэрхийлж чадах 3 цэг сонгон жилд хоёр удаа үзэгдэл зүй болон, ургацын судлах зорилгоор судалгааг эхлүүлсэн.	10	100%
Орчны хяналт шинжилгээ	12. 1. 5	Хөрсний чанарын хяналт	Хөрсний шинжилгээ	Уурхай орчмын хяналтын цэгүүдийн хөрсний шинжилгээг хийлгэсэн агрохимийн болон хөрсний ус-физикийн шинж чанарыг шинжлүүлсэн.	10	100%
	<b>ОХШХТөлөвлөгөө</b>					<b>50</b>
Талуудад тайлагнах	13. 1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг танилцуулах уулзалт	Оролцогчдын зураг	1,2-р багийн иргэд болон сумын удирдлага оролцсон хэлэлцүүлэг болов.	20	100%
	13. 2	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг Дэлгэрхангай сумын 2-р багийн малчин иргэдэд танилцуулах	Төслийн талбайд		20	100%
	13. 3	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг сумын иргэд болон сумын удирдлагуудад танилцуулах	Соёлын төвд		40	100%
	<b>Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө</b>					<b>100</b>